



САНГИЙН ЯАМ



ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2017.12.25

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх СЯ-1605 тоот гэрээг Захиалагч Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Гүйцэтгэгч байгууллагаар Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг оролцож, 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан болно.

Тус гэрээний хугацаа 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болж байгаа тул гэрээний гүйцэтгэлийн тайланг гэрээний тусгай нөхцлийн, үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын, үйл ажиллагааны хуваарийн, үндсэн орон тооны боловсон хүчний, орон тооны бус бүрэлдэхүүний, үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэлийн гүйцэтгэл, хавсралтууд гэсэн ангилал тус бүрээр тайлагнав.

Товчилсон нэр томъёо:

ТМЗҮТХ - Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль

ТМЗН - Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг

ТМЗҮ - Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ

ТМЗ - Татварын мэргэшсэн зөвлөх

ГЕН - Гэрээний ерөнхий нөхцөл

ГТН - Гэрээний тусгай нөхцөл

11. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ТМЗН нь ТМЗҮТХ, Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоол, ТМЗН-ийн дүрмийн дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хүрээнд үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн болно.

1.1. Гэрээний тусгай нөхцөлийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн хэрэгжилт

ГТН-3.1.1. ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг тус тус батлуулан мөрдүүлж, шалгалтыг зохион байгуулах;

ТМЗ-д эрх олгох, эрхийг сунгах сургалтын хөтөлбөрийг 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Сангийн яамны НБББГ-т хүргүүлж батлуулан, хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:

Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох сургалт

- Улаанбаатар хотод: 2016 оны 2 хагас жилд ТМЗ-д эрх олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж 77 нягтлан бодогч, 2017 онд нийт 7 удаагийн сургалт зохион байгуулагдаж 185 нягтлан бодогч хамрагдаж, нийт 258 суралцагчид батламж авсан.
- Орон нутагт: Орхон, Дархан-уул, Ховд, Төв аймгуудад ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтыг 5 удаа зохион байгуулж 74 нягтлан бодогч хамрагдаж, 74 суралцагчид батламж авсан. /Хавсралт-1 харуулав/

Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх сунгах сургалт

- ТМЗ-ийн эрхийг анх удаа сунгах сургалтыг 2016 оны 2 хагас жилд Улаанбаатар хотод 2 удаа зохион байгуулж 59, ТМЗ-ийн эрхийн хугацааг 2 буюу түүнээс дээш удаа сунгах сургалтыг 1 удаа зохион байгуулж, 102 гишүүд тус тус хамрагдаж ТМЗ-ийн эрхээ сунгуулсан.
- 2017 онд эрх сунгах анх удаа сургалтыг 3 удаа зохион байгуулж 137, 2 буюу түүнээс дээш удаа эрх сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж 139 суралцагч тус тус хамрагдсан байна. /Хавсралт-2 харуулав/

Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам

- Сангийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 82 дугаар тоот тушаалаар “Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам” шинэчлэгдэн батлагдсан бөгөөд энэхүү журамд заасны дагуу шалгалтыг зохион байгуулж байна.
- Журмыг таниулах ажлын хүрээнд “Татвар ба бизнес” сэтгүүлийн 19 дүгээр дугаарт болон www.cpta.mn сайт, www.facebook.com/MCPTAA/ нийтэлж нийт гишүүд, суралцагч нарт хүргэсэн.
- Шинэчлэгдсэн журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сорил шалгалт авах журам”-ыг шинээр боловсруулан ТМЗН-ийн 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн удирдах зөвлөлийн 006 тоот тогтоолоор батлуулан мөрдөж байна.
- Сорил шалгалтыг 2017 онд Улаанбаатар хотод нийт 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 131 нягтлан бодогч, Орхон аймагт 1 удаа зохион байгуулж 17 нягтлан бодогч хамрагдсан.

Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах

Сангийн сайдын 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 245 тоот тушаал, 2017 оны 5 дугаар сарын 16-ны өрдийн 170 тоот тушаалаар батлагдсан шалгалтын бүрэлдэхүүн нь ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах журмын дагуу ТМЗ-д эрх олгох, эрхийг сунгах шалгалтыг зохион байгуулж байна. Үүнд:

- ТМЗ-д эрх олгох шалгалт Улаанбаатар хотод: 2016 оны сүүлийн хагас жилд 146 нягтлан бодогч хамрагдсанаас 59 нягтлан бодогч, 2017 оны эхний хагас жилд 147 нягтлан бодогч хамрагдсанаас 33 нягтлан бодогч тус тус тэнцэж ТМЗ-ийн эрхийг авсан байна.
- ТМЗ-ийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтыг зохион байгуулсан Ховд, Орхон, Дархан-Уул, Төв аймгуудад ТМЗ-ийн эрх олгох шалгалтыг тус тус зохион байгуулж нийт 74 нягтлан бодогч хамрагдсанаас 18 нягтлан бодогч тэнцэж ТМЗ-ийн эрх авсан байна.

ТМЗ-ийн эрхийг сунгах шалгалтад 2016 оны сүүлийн хагас жилд 160 гишүүн, 2017 оны эхний хагас жилд 173 гишүүд тус тус хамрагдаж ТМЗ-ийн эрхээ сунгуулсан байна.

ГТН-3.1.2. ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх; татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангаж, тэдгээрийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх;

ТМЗҮТХ батлагдснаар нийт 60 хуулийн этгээд ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2017 оны 12 дугаар сарын байдлаар нийт 41 хуулийн этгээд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Сангийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 100 дугаар тоот тушаалаар СЯ, ТЕГ, ТМЗН хамтарсан 12 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон, ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд 2017 оны 4 дүгээр сарын 19-28-ний өдрүүдэд хяналт шалгалт хийж, арга зүйн удирдлага, зөвлөгөө өгч ажиллаа. Хяналт шалгалтад 24 хуулийн этгээд хамрагдаж, 8 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түр түдгэлзүүлээд байна. Хяналт шалгалтаар ТМЗҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заалтыг нийтлэг зөрчил илэрсэн байна. /Хавсралт-3,4,5 харуулав/

ГТН-3.1.3. Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг Захиалагчид тавьж шийдвэрлүүлэх;

Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах, хэрэгжилтэнд хяналт тавих

ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 9 дүгээр сарын 27-ний өдрийн 006 тоот тогтоолоор “Ёс зүйн дүрэм”-д өөрчлөлт оруулан баталж, мөрдөж байна. Ёс зүйн хяналтын менежментийн хороо нь шинэчлэгдсэн журмын хүрээнд “Өргөдөл гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам”-ын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

ТМЗҮТХ болон ТМЗН-ийн Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахаар хөндлөнгийн мэдээлэл авах 76009900 дугаарыг ажиллуулж эхлээд байна. /Хавсралт-6 харуулав/

Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох

2016 оны сүүлийн хагас жилд ТМЗ-ийн эрхийн хугацаа нь дууссан, сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй нийт 16, 2017 онд ТМЗ-ийн эрхийн хугацаа нь дууссан, сунгуулах хүсэлтээ

ирүүлээгүй 46 гишүүдийн эрхийг тус тус хүчингүйд тооцуулах саналыг 2017 оны 6 сард Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлсэн байна.

ГТН-3.1.4. Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоож мөрдүүлэх;

Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоосон хэмжээнд даган мөрдүүлсэн.

ГТН-3.1.5. Шалгалтын тестийн сан бүрдүүлэх, татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх;

Шалгалтын тестийн сан бүрдүүлэх

Шалгалтын тестийн санг баяжуулах зорилгоор сургалт судалгааны менежментийн хорооноос ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд сургалтад хичээл тогтмол заадаг багш нараас хөтөлбөрийн агуулгад нийцсэн тестүүдийг авч, нэгтгэн ажиллаж байна.

Судалгааны ажил хэрэгжүүлэх

ТМЗН-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хийх судалгааг дэмжиж, хөгжүүлэхийн зэрэгцээ эдгээр салбарт тулгамдаж буй асуудлыг судалж илрүүлэн, түүнээс гарах арга зам, шийдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлан боловсруулан олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлэх зорилготойгоор Судалгааны төвийг байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ зорилгын хүрээнд ТМЗ-ийн эрхээ сунгуулах гишүүдээр бие даалт болон судалгааны ажил хийлгүүлж байна.

ГТН-3.1.6. Тус гэрээнд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхдээ татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах сургалт, шалгалтыг төлбөртэй зохион байгуулж болох бөгөөд 1 цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг; 1 цагийн шалгалтын төлбөрийн дээд хязгаарыг 8000 /найман мянга/ төгрөг байхаар тооцох;

ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын 1 цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг, 1 цагийн шалгалтын төлбөрийн дээд хязгаарыг 8000 /найман мянга/төгрөг байхаар тогтоож дагаж мөрдөж ажилласан.

ГТН-3.1.7. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагч болон холбогдох байгууллагад нь ирүүлж байх;

МУ-ын татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэд, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын

хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагчид хүргүүлж ажилласан.

ГТН-3.1.8. Нийгэмлэг өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэний хувьд төлөх татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байх;

Бүх гишүүдийн хурал болон удирдах зөвлөлийн хуралдаанаар Татварын мэргэшсэн зөвлөхийн гишүүний татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөг, Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/ төгрөг, Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байхаар тогтоож, мөрдөж ажилласан.

ГТН-3.1.9. Гэрээ гүйцэггэгч нь гэрээний 3.1.6, 3.1.8-д зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүй байх;

ТМЗН нь гэрээнд зааснаас бусад аливаа төлбөр, хураамж татварыг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүйгээр, хүлээсэн үүргээ биелүүлсэн болно.

1.2. Гэрээний хавсралтын хэрэгжилт

Хавсралт А-Үйлчилгээний тодорхойлолт ба хуваарь

ТМЗН нь ТМЗҮТХ-ийн 18 дугаар зүйлийг үндэслэн энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

А-1 Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын хэрэгжилт

Үйлчилгээ 1- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт

Сургалтын 70 дээш хувьд хамрагдсан нягтлан бодогчдод батламж олгож, шалгалт өгөх эрхийг нээж өгсөн. Сургалтын ирцийг хянаснаар суралцагчдын идэвхи, чанар сайжирсан санал асуулгыг дүнгээс харагдаж байна.

Үйлчилгээ 2- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт

ТМЗ болон татвар төлөгч иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан сэдвүүдээр тасралтгүй боловсрол олгох сургалтыг зохион байгуулахын зэрэгцээ татварын хууль тогтоомжийн шинэчлэл өөрчлөлт, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ТМЗ-ийн эрхийн хугацааг сунгуулах гишүүдээр судалгааны ажил хийлгэж, хамгаалуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Эдгээр ажлын үр дүнд татварын мэргэшсэн зөвлөхүүдийн оролцоо идэвхи сайжирч, чанар, чадвар нэмэгдэж байна.

Үйлчилгээ 3- Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвөлгөө мэдээллээр хангах

ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн удирдах ажилтны зөвөлгөөнийг тогтмол зохион байгуулж, дагаж мөрдөх ерөнхий стандартыг боловсруулан гаргасан. Стандартын хэрэгжилттэй холбоотой санал хүсэлтийг Зөвлөх үйлчилгээний менежментийн хороо хүлээн авч сайжруулан ажиллаж байна.

Үйлчилгээ 4- Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх

Сургалт судалгааны менежментийн хороо нь тестийн санг шинэчилэн баяжуулах зорилгоор ТМЗН-д хичээл заадаг багш нараас хичээлийн чиглэл тус бүрээр тест авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

А-2 Үйл ажиллагааны хуваарийн хэрэгжилт /2016-2017/

ТМЗН нь энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн болно. Үүнд:

| Үйл ажиллагааны нэр төрөл | Хэрэгжилт |
|--|---|
| Үйл ажиллагааны урьдчилсан тайлан, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт | 2017 оны 2 дугаар сарын 9-ны өдрийн 02/06 тоот албан бичгээр үйл ажиллагааны тайлан, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг захиалагчид хүргүүлсэн. |
| Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт | 2017 оны 2 дугаар сарын 9-ны өдрийн 02/06 тоот албан бичгээр жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт захиалагчид хүргүүлсэн. |
| Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгоход бэлтгэх сургалт | СЯ-ы НБББГ-г хүргүүлсэн хөтөлбөрийн дагуу ТМЗ-д эрх олгох сургалтыг зохион байгуулсан. |
| ТМЗ-д эрх олгох шалгалт | Сангийн сайдын тушаалаар томилогдсон шалгалтын комисс нь 2016 оны 12 сард, 2017 оны 6,12 саруудад зохих журмын дагуу шалгалтыг зохион байгуулж ажилласан. |
| ТМЗ-ийн эрх сунгах тасралтгүй боловсролын сургалт | Батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдаж байна. |
| ТМЗ-ийн эрх сунгах шалгалт | Зохих журмын дагуу 2016 оны 12 сард, 2017 оны 6,12 саруудад ТМЗ-ийн эрх сунгах шалгалтыг зохион байгуулж байна. |
| ТИНБ-2017 чуулган | “ТИНБ-2017” чуулганаар татварын хуулийн хэрэгжилт болон тулгамдсан асуудлуудын хүрээнд хийгдсэн судалгааг олон нийтэд таниулах, татварын алба болон холбогдох төрийн байгууллагуудын баримталж буй бодлого, шинэчлэлийг олон нийтэд түгээхийг зорилготогоор 6 дугаар сарын 16-ны өдөр “Чингис” зочид буудалд зохион байгууллаа. Тус чуулга уулзалтад нийт 154 төлөөлөгч оролцлоо. |
| ТМЗ-ийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ | ТМЗҮТХ-г суртчилан таниулахтай холбоотойгоор ТМЗ-ийн тангараг өргөх ёслол"-ын арга хэмжээг холбогдох төрийн байгууллагууд хамтран зохион байгуулж байна. Үүнд: 2016 оны сүүлийн хагас жилд ТМЗ-ийн эрхийг шинээр 68 гишүүн авч, 219 гишүүн ТМЗ-ийн эрхээ сунгуулсан бол; 2017 оны эхний хагас жилд ТМЗ-ийн эрхийг шинээр 51 гишүүн, ТМЗ-ийн эрхээ 173 гишүүн тус тус сунгуулан гэрчилгээ, энгэрийн тэмдэгээ гардан авч ТМЗ-ийн эрхийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйгээ чандлан сахихаа батлан тангарагласан байна. |
| Татварын бүртгэл- онлайн олимпиад | Татварын хууль тогтоомжийг таниулан суртчилдаг “ТАТВАРЫН БҮРТГЭЛ” олимпиадыг нягтлан бодогч, оюутан залуус гэсэн 2 ангилалд, 2 үе шатаагаар Сангийн яам, Татварын ерөнхий газар, Новасофт ХХК-тай хамтран амжилттай зохион байгуулж байна. <i>Татварын бүртгэл-2016</i> олимпиадад нийт 560 оролцогч өрсөлдөж, 2-р шатны тэмцээнд ангилал тус бүрээс шилдэг 20 оролцогч шалгарч, тус олимпиадын шилдгээр 6 оролцогч шалгарсан. <i>Татварын бүртгэл-2017</i> олимпиадыг ТМЗН-ийн үүсгэн байгуулагч, хүндэт ерөнхийлөгч, МУ-ын татварын итгэмжит зөвлөх Я.Мишиглүндэнгийн нэрэмжит болгон зохион байгуулсан бөгөөд олимпиадын 2 ангилалд нийт |

| | |
|---|--|
| | 389 оролцогч өрсөлдөж, шилдгээр 6 оролцогч шалгарсан байна. |
| “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?” оюутны тэмцээн | ТМЗН нь Татварын Ерөнхий газар, Нийслэлийн Татварын газар, ТМЗҮ эрхлэгч хуулийн этгээдүүдийн төлөөлөл компаниуд болон НЗДТГ-тай хамтран “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?” тэмцээнийг телевизийн танин мэдэхүйн уралдаант нэвтрүүлэг хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийслэлийн зургаан дүүргээс шалгарсан СЭЗДС, ОУЭЗБДС, МУИС-ийн БС, МанБДС, УБЭОДС,ХААИС-ийн багууд ТМЗҮ эрхлэх хуулийн этгээдүүд, дүүргүүдийн татвар хэлтэс, шилдэг татвар төлөгчдийн төлөөлөлтэй хамтран НӨАТ-ын хууль болон е-баримтыг хэрэгжүүлэх, хэвшүүлэх талаар шинэ санаа, санаачлага гарган амжилттай оролцлоо. |
| Спортлог ТИНБ-2016 | “Спортлог ТИНБ-2016” хоёр дах удаагийн спортын наадмыг 10 сарын 28-29 –ний өдрүүдэд гар бөмбөг, ширээний теннис, боулингийн төрлөөр ТМЗН-ийн гишүүд, хуулийн этгээдүүдийн дунд амжилттай зохион байгууллаа. Нийт 8 багийн 130 гаруй тамирчид өрсөлдөж шилдгээ шалгаруулсан байна. Спортын наадмын ерөнхий зохион байгуулагчаар “Хүлэг Консалтинг ТМЗ” ХХК, “Силвэр финанс ТМЗ” ХХК, “Монголтакс ТМЗ” ХХК хамт олон ажилласан. |
| “Шилдэг-2016 “ - ТМЗ-ийн баяр | <i>ТМЗ-ийн баяр-2016</i> шинэ жилийн цэнгүүнийг 2016 оны 12 сарын 24-нд зохион байгуулан шилдэг ТМЗ-рөөр З.Намхайнямбуу, шилдэг багшаар МУИС-ийн БС-ийн багш О.Пүрэвдорж, ТМЗН-ийн шилдэг ажилтнаар Г.Хишигзул нар тус тус шалгарлаа. <i>ТИНБ-ын баяр 2017</i> шинэ жилийн цэнгүүнийг 2017 оны 12 сарын 27-нд зохион байгуулахаар төлөвлөөд байна. |
| ТМЗН-ийн бүх гишүүдийн хурал | ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит IV их хурлыг 2017 оны 5 дугаар сарын 12-нд Төрийн ордонд зохион байгууллаа. Ээлжит их хуралд ТМЗН-ийн 19 салбар, 1200 гаруй гишүүдийн төлөөлөл болсон 200 орчим ТМЗ-үүд оролцож, нийгэмлэгийн 2013-2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, дараагийн дөрвөн жилд ажиллах Удирдах зөвлөлийн 11 гишүүн, Хяналтын зөвлөлийн 5 гишүүдийг шинээр сонгон ажиллаж байна. |
| ТМЗ-ийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн уулзалт зөвлөгөөн | ТМЗН-ийн Зөвлөх үйлчилгээ менежментийн хороо хариуцан ТМЗ-ийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн ээлжит уулзалт зөвлөгөөнийг 2017 оны 6 сарын 11-нд зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр ТМЗ тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдэд хийсэн хяналт шалгалтын дүнг танилцуулан, тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал солилцсон. |
| АОТСА-2016,2017 хуралд оролцох | <i>АОТСА-2016</i> Ази Номхон Далайн Орнуудын Татварын Зөвлөхүүдийн Холбоо (АОТСА) 14-дэх удаагийн олон улсын бага хурал 2016 оны 10-р сарын 5-7 өдрүүдэд Гонконгод амжилттай зохион байгууллаа.Хуралдаанаар “Post BEPS, Opportunities and Challenges” буюу “BEPS-ийн дараахь Боломж ба Сорилууд”сэдвийн дор явагдсан бөгөөд олон улс дахь үндэстэн дамнасан корпорацуудын ажиллагаа, татварын суурийг багасгах замаар ашгийг зувчуулах асуудлууд болоод “BEPS-15 Ажиллагаа” |

| | |
|---|--|
| | <p>зөвлөмжийг АОСТА гишүүн орнууд хэрхэн хүлээн авсан талаар хэлэлцэв. ОУ-ын бага хурлаас АОТСА-гийн 2018 оны 16 дах хуралдааныг Улаанбаатар хотноо хийхээр шийдвэрлэсэн байна.</p> <p>АОТСА-2017 ээлжит олон улсын хурал Бүгд Найрамдах Филиппин улсын Манила хотод аравдугаар сарын 18-20-нд зохион байгуулагдаж, ТМЗН-ийн 26хүний бүрэлдэхүүнтэй баг оролцлоо. Хурлаар ОУ-ынорчинд үүссэн чухал асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд BEPS буюу Татварын Суурийг Багасгаж Ашгийг Зувчуулахтай холбоотой асуудлууд голчлон хөндөгдсөн. Хуралд BEP5 буюу Татварын Суурийг Багасгаж Ашгийг Зувчуулах асуудал, Үнэ шилжилт, BEP3-ийн дараах хэрэгжилт ба холбогдох хөгжлүүд, АНУ-ын Татварын хөгжил / шинэчлэл, түүний бүс нутагт үзүүлэх нөлөө/, Татвар төлөгчийн дүрмийн төсөл дээрх эцсийн тайлан, Татварын маргааныг шийдвэрлэх, буцаан олгох үйл явц, Татварын шинэчлэл / Азийн орнууд/, Татварын менежмент дэх нэмэгдэж буй ЖДҮ эсвэл технологийн гүйцэтгэх үүрэг, Татвар төлөлтийн байдал, судалгаа, Улс орны тойм-Татварын албаны туршлагазэрэг сэдвүүдээр илтгэл тавигдсан байна. АОТСА-2017 ОУ-ын бага хуралд ТМЗН-ийн УЗ-ийн гишүүн, "Прайс Вотер Хаус Күүперс Такс ТМЗ" ХХК-ний татварын ахлах зөвлөх Ж.Энхзул Монгол Улсаа төлөөлөн "НӨАТ-ын цахим системийг Монголд хэрэгжүүлэх нь" сэдвээр илтгэл хэлэлцүүлж, МУ-ын ТМЗН-ийн түвшинг олон улсад таниуллаа.</p> |
| <p>Монгол-Японы мэргэшсэн зөвлөхүүдийн бага хурал</p> | <p>Монгол-Японы ТМЗҮ-ний нийгэмлэгүүдийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол-Японы ТМЗ-үүдийн II бага хурлыг 2016 оны 9 сарын 20-ний өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Бага хуралд Япон Улсын ТИНБ-дын Нэгдсэн холбооноос 15 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцож, хоёр орны ТМЗҮ-ний тогтолцоо, НӨАТ-ын хууль, Газрын үнэлгээ, бүртгэл, татвар ногдуулалт, Эдийн засгийн түншлэл, Хамтын ажиллагааны үндсэн зорилго, үр нөлөө гэсэн сэдвүүдийг хэлэлцэж, туршлага солилцсон байна.</p> |

Хавсралт Б-Тайлагнах үүрэг хариуцлага

ТМЗН-ийн 2017 оны 2 дугаар сарын 9-ны өдрийн 02/06 тоот албан бичгээр үйл ажиллагааны тайланг /урьдчилсан байдлаар/ дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг, үйл ажиллагааны тайлангийн хамт Захиалагч талд хүргүүлж ажилласан.

Хавсралт В-Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин

В-1 Үндсэн орон тооны ажилтан

| <i>Албан тушаал</i> | <i>Нэр</i> | <i>Тавигдах шаардлага</i> | <i>Чухал шаардлага, ур чадварын хангасан байдал</i> |
|--|-------------|---|---|
| Ерөнхийлөгч | Г.Алтанзаяа | Дээд боловсролтой, Доктор, профессор | ТМЗН-ийн үүсгэн байгуулагч, 2004 оноос хойш нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Татварын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлээр 22 ном гаргаж, 22 илтгэл, 20 өгүүлэл хэлэлцүүлж, 8 төсөл, судалгааны ажил хийсэн байна. МУ-ын ТМЗ, МНБ |
| Гүйцэтгэх захирал | Ц.Болормаа | Дээд боловсролтой | 2005 оноос хойш ТМЗН-т сургалтын менежер, ажлын албаны дарга, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. |
| Ажлын албаны дарга/ Тамгын газрын дарга | Г.Хишигзул | Дээд боловсролтой | 2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн багш, тамгын газрын даргаар ажиллаж байна. Магистр зэрэгтэй. |
| Сургалтын менежер | Б.Уранбилэг | Дээд боловсролтой, магистр зэрэгтэй | 2010 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологийн менежер, нягтлан бодох бүртгэлийн багш, сургалтын менежерээр ажиллаж байна. Магистр зэрэгтэй. МУ-ын ТМЗ. |
| Нягтлан бодогч | Г.Хишигзул | Дээд боловсролтой, магистр зэрэгтэй | 2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогчоор ажиллаж байна. Магистр зэрэгтэй. МУ-ын ТМЗ, МНБ |
| Мэдээлэл технологийн инженер | Ц.Тулга | Дээд боловсролтой | 2015 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологийн инженерээр ажиллаж байна. |
| Мэдээлэл технологийн менежер | Ү.Ганболд | Дээд боловсролтой | 2016 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологийн менежерээр ажиллаж байна. |
| Гишүүд, олон нийт, орон нутгийн салбар хариуцсан ажилтан | Ц.Хажидмаа | Дээд боловсролтой | 2006 оноос хойш ТМЗН-т Гишүүд, олон нийт, орон нутаг хариуцсан менежерээр ажиллаж байна. |
| Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан захирал | Х.Батсуурь | Дээд боловсролтой, англи хэлний өндөр мэдлэгтэй | 2016 оноос хойш ТМЗН-т Судалгааны төв, гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байна. |
| Судалгааны ажилтан | Ц.Баярхүү | Дээд боловсролтой, магистр зэрэгтэй | 2016 оноос хойш ТМЗН-т судалгааны ажилтнаар ажиллаж байна. Магистр зэрэгтэй. |

В-2 Орон тооны бус бүрэлдэхүүн

| <i>Албан тушаал</i> | <i>Тавигдах шаардлага хангасан байдал</i> |
|---------------------|--|
| Удирдах зөвлөл | ТМЗН-ийнбүх гишүүдийн ээлжит IV их хурлаар /2017 оны 5 дугаар сарын 12 өдрийн/ удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий ТМЗ гишүүд удирдах зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 11 гишүүн сонгогдсон болно. |
| Хяналтын зөвлөл | ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит IV их хурлаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүд хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 5 гишүүн сонгогдсон болно. |
| Менежментийн хороод | ТМЗН-ийн УЗ-ийн 2017 оны 9 дугаар сарын 27 өдрийн хуралдаанаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүдийгменежментийн хороонд ажиллуулахаар томилсон болно. |

Хавсралт Г-Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл

| <i>Үйлчилгээ</i> | <i>Үйлчилгээний төрөл</i> | <i>Техник хэрэгсэл</i> |
|------------------|--|---|
| Үйлчилгээ 1 | Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт | <ul style="list-style-type: none"> • <i>Сургалтын анги танхим:</i> 40 суралцагчийн багтаамжтай, ухаалаг самбар, проектор, компьютер зэрэг иж бүрэн хэрэгсэлээр тоноглогдсон. /Хавсралт-7/ • <i>Сурах бичиг гарын авлага:</i> Сургалтын батлагдсан хөтөлбөрийг агуулсан ном сурах бичиг, гарын авлагын бэлтгэн, тухай бүр шинэчлэн суралцагчдад өгдөг. /Хавсралт-8/ • <i>Багшлах боловсон хүчин:</i> Хичээл тус бүрт тухайн чиглэлээр ажилласан туршлагатай нарийн мэргэшсэн мэргэжилтэн, их дээд сургуулиудын багш, татварын мэргэшсэн зөвлөх нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг. /Хавсралт-9/ |
| Үйлчилгээ 2 | Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт | |
| Үйлчилгээ 3 | Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангах | |
| Үйлчилгээ 4 | Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх | |